



БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
О.БЯМБАДОРЖ ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.09.04 № 574

танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн О.Бямбадоржийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

011021650

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч 213713921641 бүртгэлийн дугаартай Оюунцэцэг овогтой Бямбадоржийн Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч О.Бямбадоржийн мөрийн хөтөлбөр 1 хуудас хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч "О.Бямбадорж"-д

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

**ДОРНОД АЙМГИЙН ЧОЙБАЛСАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ОЮУНЦЭЦЭГИЙН БЯМБАДОРЖИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

1. Сумын хөгжлийн бодлого, төсөв, тухайн жилийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх зорилтуудыг боловсруулах батлахдаа иргэдийн саналыг авч, тусгах, хэрэгжилтийг танилцуулах ажлыг хэрэгжүүлнэ.
2. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төрийн үйлчилгээний авахад зарцуулагдах цагийг багасгахад техник технологи болон иргэдийн сэтгэл ханамжид нийцсэн менежментийн ашиглана.
3. Төрийн албан хаагчдын урамшууллын тогтолцоонд иргэдийн үнэлэмжийг ашиглах тогтолцоог эхлүүлж иргэн-төр-иргэн гэсэн эргэх холбоог бэхжүүлнэ.
4. Төрийн албан хаагчдыг тасралтгүй суралцаж, мэдлэг чадвараа дээшлүүлэхэд онцгой анхаарч ажиллана.
5. Сумын төвийн айл өрх, аж ахуйн нэгж, албан байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбоно.
6. Жишиг гудамж төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
7. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн эзлэх хувийг нэмэгдүүлж, иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн шинээр байгуулна.
8. Хулстай гудамжны урд байрлах Гурвалжин талбайн модны ашиглалтыг сайжруулж тохижилтын ажлыг эхлүүлнэ.
9. Нийтийн эзэмшлийн газруудын хогийн савны тоог нэмэгдүүлнэ
10. Ундны усны авах уст цэгийн зайг багасгана.
11. Сумын эрүүл мэндийн төвд шүдний кабинет ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
12. Сумын Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчилнэ.
13. Ахмадын болон хүүхдийн сувиллыг үргэлжлүүлэн ажиллуулж үр дүнд анхаарна.
14. Нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна.
15. Сумын төвийн болон суурин газруудын ундны усыг стандартын шаардлага болон иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн шийдвэрлэнэ.
16. Өглөө оройны дасгал хөдөлгөөн хийх орчин нөхцөлийг шийдвэрлэнэ.
17. Эрүүл амьдралын хэв маягийг таниулах, хэвшүүлэх бүхий л арга хэмжээг дэмжинэ.
18. Сумын иргэдийн дунд зонхилон тохиолдолд өвчлөлийн судалгааг гаргаж, шалтгаан нөхцөлийг арилгах нөлөөллийн ажлыг зохион байгуулна.
19. Англи хэлний эрчимжүүлсэн сургалттай зуны зуслан ажиллуулна.
20. Багш нарыг мэргэжил дээшлүүлэх, ур чадвараа дээшлүүлэх сургалт, туршлага солилцох дэмжлэг үзүүлнэ.
21. Ерөнхий боловсролын сургуультай хамтран элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж онооны чанарыг 20 хувиар нэмэгдүүлнэ.
22. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
23. Сургуулийн номын сан, хүүхдийн цэцэрлэгийн тоглоом хэрэглэгдэхүүнд тогтмол баяжилт хийнэ.
24. Алслагдсан бэлчээрийг усжуулж, бэлчээр сэлгэлтийг сайжруулна.
25. Хөдөөгийн багуудад гүн өрмийн худгийг шинээр гаргах, бэлчээрийг нөхөн сэргээх ажлыг малчидтай хамтран хэрэгжүүлнэ
26. Хэрлэн голд татмын ойжуулалт хийнэ.
27. Гамшгийн эрсдэлийг хохирол багатай даван туулах, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллага, олон улсын сайн дурын байгууллага болон иргэдийн оролцоотойгоо хэрэгжүүлнэ.
28. Сумын хадлангийн салаа болон малчдын бүлгээр хадлан тэжээл бэлтгэхийг дэмжинэ.
29. Малын үйлдвэр угсааг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх ажлыг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
30. Малын тооноос хамаарсан татвар бодлого баримтална.

